



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Сургуулийн орчинд гар утас, цахим  
хэрэгслийн хэрэглээний талаар авах  
арга хэмжээний тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.5 дугаар заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Боловсролын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, эцэг эхчүүдээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн, цахим хэрэгслийн зохисгүй хэрэглээний сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагч хичээллэх цагаар гар утас хэрэглэхийг хориглосугай.

2. Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгох нь:

2.1. Сургуулийн орчинд цахим хэрэгслийг зохистой ашиглах асуудлыг сурагчдын эцэг эх, асран хамгаалагчтай хэлэлцэж гэрээ байгуулах, хүүхэд хамгаалалтай холбоотой холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласугай.

2.2. Сургуулийн дүрэмд доорхи чиглэлээр нэмэлт оруулан баталж мөрдүүлсүгэй.

2.2.1. сургуулийн орчинд гар утас, цахим хэрэгсэл, цахим сүлжээг хэрэглэх талаар судлах, хүүхдийг цахим хэрэгсэлд донтох байдлаас хамгаалах;

2.2.2. цахим сүлжээний хяналтгүй хэрэглээ нь хүүхдийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг талаар сургууль, эцэг эх асран хамгаалагч нартай хамтран мэргэжлийн байгууллагын тусламжтай сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмолжуулах;

2.2.3. сурагчид цахим сүлжээ, гар утас, бусад цахим хэрэглэгдэхүүний хэрэглээнээс хамаарч гэмт халдлага, хүчирхийллийн хохирогч болох, нийгмийн ализаа хорт зуршлын нөлөөнд автахгаас урьдчилан сэргийлэх;

2.2.4. сурагчдын хэрэглэж буй гар утас, цахим хэрэгслийн ялгаатай байдлын улмаас үүсэх тэгш бус байдал, харилцааны зөрчил үүсэхээс хамгаалах.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, нийслэлийн Боловсролын газарт тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн зохицуулах газар /М.Мөнхбаатар/, хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ хийж, дүнг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны дотор танилцуулахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-т тус тус даалгасугай.



Ж.БАТСУУРЬ